



# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

## ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2026/024/-НА-СТА-ТТЗ

ТӨВ АЙМГИЙН БАЯНЧАНДМАНЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН 2025  
ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД  
ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2026 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: [khishigjargalts@audit.gov.mn](mailto:khishigjargalts@audit.gov.mn)

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: [amarjargalo@audit.gov.mn](mailto:amarjargalo@audit.gov.mn)

Аудитор: Б.Адъяасүрэн

Утас: 70273204 Цахим хаяг: [adiyasuren@audit.gov.mn](mailto:adiyasuren@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг  
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: [www.open.audit.mn](http://www.open.audit.mn)

## АГУУЛГА

<b>1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....</b>	<b>3</b>
<b>2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ</b>	<b>5</b>
<b>3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....</b>	<b>10</b>
<b>3.3 Зөвлөмж.....</b>	<b>10</b>
<b>4. Санхүүгийн тайлангийн аудитад хамрагдсан байгууллагуудын санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл.....</b>	<b>11</b>
<b>5. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ .....</b>	<b>11</b>

### **Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн газар



**ТӨВ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100, Төв аймаг, Зуунмод сум  
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn  
Цахим хаяг: www.audit.mn

2025.03.21 № 01/250  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ТӨВ АЙМГИЙН БАЯНЧАНДМАНЬ  
СУМЫН ЗАСАГ ДАРГА  
А.УУГАНБИЛЭГ ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-д заасны дагуу Төв аймгийн Баянчандмань сумын Засаг даргын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар фермийн хорооны 2.7 км сайжруулсан зам засварыг 260,438.7 мянган төгрөгөөр, нийгмийн хариуцлагын гэрээгээр нарны зайн 150 ширхэг гэрэлтүүлгийг 82,500.0 мянган төгрөгөөр, асфальтан 300 метр замыг 299,238.5 мянган төгрөгөөр хийж аюулгүй, тав тухтай ажиллаж амьдрах орчин бүрдүүлж ажилласан байна.

**Аудитын гол асуудал**

Сумын төсвийн хөрөнгөөр 1,431,430.8 мянган төгрөгийг 30 зардал, төсөл, арга хэмжээнд санхүүжилт баталснаас 1,304,130.8 мянган төгрөгийг 23 хөрөнгө оруулалт, тоног төхөөрөмж, засварын ажилд төлөвлөж, 519,192.4 мянган төгрөгийн 19 ажлын гэрээ байгуулагдсан байна.

**Бусад асуудлын хэсэг**

Төв аймгийн Баянчандмань сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2025 оны 12 дугаар сарын 19-ний 01 дүгээр тогтоолоор сумын Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт дэвшүүлсэн 88 зорилт 169 арга

• 4126020638

хэмжээний хэрэгжилтийн явцыг 82,2%-тай буюу “Үр дүн хүлээгдэж байгаа” гэж дүгнэсэн байна.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		2,309,557.95	2,801,310.6
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	1,278,333.72	2,029,292.18
33	АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	777,958.29	497,083.55
35	БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	253,265.94	274,934.87
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		4,408,713.25	5,844,451.1
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б, 12в	4,408,713.25	5,844,451.1
39200	Биет хөрөнгө		3,069,335.25	4,480,058.76
39300	Биет бус хөрөнгө	13	1,339,378	1,364,392.33
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II		6,718,271.19	8,645,761.7
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР		14,581.77	162,910.6
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		14,581.77	162,910.6
41300	Өглөг		14,581.77	162,910.6
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		6,703,689.42	8,482,851.1
51	Засгийн газрын хувь оролцоо		6,703,689.42	8,482,851.1
51100	Засгийн газрын оруулсан капитал		923,761.96	923,761.96
51200	Хуримтлагдсан үр дүн		5,626,273.88	7,420,388.9
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		153,653.58	138,700.3
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V		6,718,271.19	8,645,761.7

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	5,609,381.39	5,809,919.04
11	ТАТВАРЫН ОРЛОГО	2,170,144.94	2,310,042.35
110	Орлогын албан татвар	1,676,962.05	1,873,169.08
1100	Хувь хүний орлогын албан татвар	1,676,962.05	1,873,169.08
113	Хөрөнгийн албан татвар	203,049.68	237,398.17
118	Бусад татвар, төлбөр, хураамж	290,133.22	199,475.11
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,605,113.42	3,499,876.68
120	Нийтлэг татварын бус орлого	0	363,175.6
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	834,123.02	0
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,468,004.15	3,262,969.17
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,464,404.15	3,128,180.05
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,267,967.24	2,760,656.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	751,218.46	926,120.27
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	94,988.31	113,263.74
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	456,613.89	509,752.99
2104	Хангамж, бараа материалын зардал	88,155.65	62,736.38
2105	Нормативт зардал	110,902.35	109,908.1
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	23,753.5	93,949.08
2107	Томилолт, зочны зардал	12,722	8,950.5
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	18,335.74	30,048.04
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	711,277.34	905,927.19
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	196,436.91	367,523.75
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	3,600	134,789.12
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	3,141,377.24	2,546,949.86
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	0	3,774.75
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	362,704.3	534,703.85
VII	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)	-362,704.3	-530,929.1
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	2,778,672.94	2,016,020.76

**2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан**  
2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/ мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	3,848,998.68	4,131,647.11
11	ТАТВАРЫН ОРЛОГО	2,170,144.94	2,310,042.35
110	Орлогын албан татвар	1,676,962.05	1,873,169.08
113	Хөрөнгийн албан татвар	203,049.68	237,398.17
118	Бусад татвар, төлбөр, хураамж	290,133.22	199,475.11
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	32,917.2	38,999.49
1181	Газрын төлбөр	150,192.76	157,717.92
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	107,023.26	2,757.7
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	849,316.1	1,821,604.75
120	Нийтлэг татварын бус орлого	849,316.1	1,144,031.55
122	Тусламжийн орлого	0	371,399.51
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	0	306,173.7
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	829,537.64	0
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,205,523.55	2,365,851.75
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,205,523.55	2,365,851.75
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,009,086.63	1,998,328
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	755,952.35	927,934.64
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	90,534.62	113,352.63
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	456,613.89	509,627.99
2104	Хангамж, бараа материалын зардал	93,380.85	60,294.9
2105	Нормативт зардал	122,360.43	120,230.4
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	70,546.5	93,561.38
2107	Томилолт, зочны зардал	12,722	8,950.5
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	20,097.89	25,124.18
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	386,878.1	139,251.38
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	196,436.91	367,523.75
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	1,643,475.14	1,765,795.35
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	1,119,473.76	918,512.51
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,119,473.76	918,512.51
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	1,119,473.76	918,512.51
2200	Дотоод эх үүсвэрээр	-1,119,473.76	-918,512.51
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	158,134.22	80,894.88
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	0	15,429.49
25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	-158,134.22	-96,324.38
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	365,867.16	750,958.47
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	912,466.56	1,278,333.72
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,278,333.72	2,029,292.18

**2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,925,016.48	3,925,016.48
2	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,925,016.48	3,925,016.48
3	Тайлант үеийн үр дүн	2,778,672.94	2,778,672.94
4	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	6,703,689.42	6,703,689.42
9	2025 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	6,703,689.42	6,703,689.42
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-221,905.78	-221,905.78
11	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	6,481,783.64	6,481,783.64
13	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-14,953.26	-14,953.26
19	Тайлант үеийн үр дүн	2,016,020.76	2,016,020.76
20	2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	8,482,851.14	8,482,851.14

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	3,259,697.7	3,631,612.3	-371,914.6	111%
11	Татварын орлого	1,998,970.3	2,310,042.4	-311,072.1	116%
110	Орлогын албан татвар	1,646,119.2	1,873,169.1	-227,049.9	114%
1100	Хувь хүний орлогын албан татвар	1,646,119.2	1,873,169.1	-227,049.9	114%
110001	Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого	1,360,000.0	1,430,683.8	-70,683.8	105%
110002	Үйл ажиллагааны орлого	30,000.0	148,470.7	-118,470.7	495%
110003	Хөрөнгийн орлого	139,119.2	140,161.4	-1,042.2	101%
110004	Хөрөнгө борлуулсны орлого	32,000.0	93,269.0	-61,269.0	291%
110006	Урлагийн тоглолт, спортын тэмцээний шагнал, наадмын бай шагнал	85,000.0	60,584.1	24,415.9	71%
113	Хөрөнгийн албан татвар	171,851.1	237,398.2	-65,547.1	138%
113001	Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	127,000.0	191,969.2	-64,969.2	151%
113002	Бууны албан татвар	1,050.0	1,594.1	-544.1	152%
113004	Малд ногдуулах албан татвар	43,801.1	43,834.9	-33.8	100%
118	Бусад татвар, төлбөр, хураамж	181,000.0	199,475.1	-18,475.1	110%
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	26,500.0	38,999.5	-12,499.5	147%
118001	Улсын тэмдэгтийн хураамж	4,000.0	10,681.9	-6,681.9	267%
118006	Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	-	900.0		
118009	Хог хаягдлын үйлчилгээний хураамж	22,500.0	27,417.6	-4,917.6	122%
1181	Газрын төлбөр	150,000.0	157,717.9	-7,717.9	105%
118101	Газрын төлбөр	150,000.0	157,717.9	-7,717.9	105%
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	4,500.0	2,757.7	1,742.3	61%
118201	Ойн нөөц ашигласны төлбөр	4,500.0	2,757.7	1,742.3	61%
12	Татварын бус орлого	1,260,727.4	1,321,570.0	-60,842.6	105%
120	Нийтлэг татварын бус орлого	952,698.9	1,015,396.3	-62,697.4	107%
120003	Торгуулийн орлого	711,198.9	888,579.9	-177,381.0	125%
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	240,000.0	107,359.2	132,640.8	45%
	/үндсэн/				
120010	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	2,090.0		
	/туслах/				
120005	Түрээсийн орлого	1,500.0	8,153.8	-6,653.8	544%
120009	Бусад орлого	-	9,213.4		
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	308,028.5	306,173.7	1,854.8	99%
123002	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого	308,028.5	306,173.7	1,854.8	99%
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	548,028.5	2,816,781.4	-2,268,752.9	514%
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,490,646.6	2,135,850.7	354,795.9	86%
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,101,606.3	1,829,338.9	272,267.4	87%
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	905,777.9	834,198.5	71,579.4	92%
210101	Үндсэн цалин	487,234.8	482,840.9	4,393.9	99%
210102	Нэмэгдэл	362,941.1	313,091.7	49,849.4	86%
210103	Унаа хоолны хөнгөлөлт	35,640.0	23,805.0	11,835.0	67%
210104	Урамшуулал	14,010.0	14,010.0	0.0	100%
210105	Гэрээт ажлын хөлс	5,952.0	450.9	5,501.1	8%
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	113,252.9	101,893.9	11,359.0	90%
210201	Тэтгэврийн даатгал	76,993.4	70,266.0	6,727.4	91%
210202	Тэтгэмжийн даатгал	9,058.0	8,322.5	735.5	92%
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,556.4	4,334.0	222.4	95%
210204	Ажилгүйдлийн даатгал	4,529.1	3,769.6	759.6	83%
210205	Эрүүл мэндийн даатгал	18,116.0	15,201.8	2,914.2	84%
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	540,224.6	509,628.0	30,596.6	94%
210301	Гэрэл, цахилгаан	109,636.2	88,505.5	21,130.7	81%
210302	Түлш, халаалт	416,917.3	416,282.5	634.8	100%
210303	Цэвэр, бохир ус	13,671.1	4,840.0	8,831.1	35%
2104	Хангамж, бараа материалын зардал	95,920.9	65,681.1	30,239.8	68%
210401	Бичиг хэрэг	13,500.0	8,383.6	5,116.4	62%

210402	Тээвэр, шатахуун	37,242.5	24,387.1	12,855.4	65%
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	7,678.4	7,023.7	654.7	91%
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	22,500.0	16,007.7	6,492.3	71%
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	15,000.0	9,879.0	5,121.0	66%
2105	Нормативт зардал	2,190.0	1,547.0	643.0	71%
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,190.0	1,547.0	643.0	71%
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	120,640.0	113,905.4	6,734.6	94%
210601	Багаж, техник, хэрэгсэл	24,640.0	24,600.0	40.0	100%
210604	Урсгал засвар	96,000.0	89,305.4	6,694.6	93%
2107	Томилолт, зочны зардал	13,500.0	8,950.5	4,549.5	66%
210702	Дотоод албан томилолт	13,500.0	8,950.5	4,549.5	66%
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	81,427.5	69,526.8	11,900.7	85%
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	75,303.2	64,846.4	10,456.8	86%
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,584.8	2,584.8	-	100%
210803	Даатгалын үйлчилгээ	950.0	650.0	300.0	68%
210804	Тээврийн хэрэгслийн татвар	704.5	524.6	179.9	74%
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	385.0	242.0	143.0	63%
210807	Газрын төлбөр	1,500.0	679.0	821.0	45%
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	228,672.5	124,007.8	104,664.7	54%
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	221,672.5	120,875.8	100,796.7	55%
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,000.0	3,132.0	3,868.0	45%
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-3,539,238.5	306,511.8	-3,845,750.3	-9%
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-3,607,696.5	259,570.4	-3,867,266.9	-7%
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	320,582.3	320,582.3	-	100%
213103	Төсвийн санхүүжилт	-3,928,278.8	-61,012.0	-3,867,266.9	2%
2132	Бусад урсгал шилжүүлэг	68,458.0	46,941.5	21,516.6	69%
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	8,360.0	900.0	7,460.0	11%
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	44,298.0	41,835.2	2,462.8	94%
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	15,800.0	4,206.3	11,593.8	27%
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,745,660.7	600,035.8	1,145,624.9	34%
221001	Их засвар	945,759.8	295,216.5	650,543.3	31%
222001	Тоног төхөөрөмж	132,359.4	89,323.5	43,035.9	67%
223001	Бусад хөрөнгө	667,541.5	215,495.8	452,045.7	32%
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	240,000.0	80,894.9	159,105.1	34%
230001	Эргэж төлөгдөх зээл	240,000.0	80,894.9	159,105.1	34%
8	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	2,711,669.2	814,830.9	1,896,838.3	30%
9	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-2,711,669.2	-814,830.9	-1,896,838.3	30%
7	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	-2,711,669.2	-814,830.9	-1,896,838.3	30%
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	1,253,681.8		
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	1,992,198.2		
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	70.0	70.0	-	
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	2.0	2.0	-	
610001	Төсвийн байгууллага	2.0	2.0	-	
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	34.0	34.0	-	
620001	Удирдах ажилтан	8.0	8.0	-	
620002	Гүйцэтгэх ажилтан	15.0	15.0	-	
620003	Үйлчлэх ажилтан	10.0	10.0	-	
620004	Гэрээт ажилтан	1.0	1.0	-	
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	34.0	34.0	-	
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	13.0	13.0	-	
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	14.0	14.0	-	
650010	Гэрээт ажилтан	1.0	1.0	-	
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	6.0	6.0	-	

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**  
2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	346,235.85	371,272.66	-25,036.80	107.2%
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	346,235.85	371,272.66	-25,036.80	107.2%
122	Тусламжийн орлого	346,235.85	371,272.66	-25,036.80	107.2%
1221	Хандив тусламж /дотоод/	346,235.85	371,272.66	-25,036.80	107.2%
12213	орлого Нэмэлт санхүүжилтийн	346,235.85	371,272.66	-25,036.80	107.2%
350013	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	96,722.46	115,751.81	-19,029.35	119.7%
350014	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	221,966.70	221,966.70	-	100.0%
350015	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	27,546.69	33,554.14	-6,007.45	121.8%
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	365,444.79	363,154.00	2,290.78	99.4%
21	УРСГАЛ ЗАРДАЛ	151,275.67	148,984.88	2,290.78	98.5%
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	151,275.67	148,984.88	2,290.78	98.5%
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	93,895.79	93,736.14	159.65	99.8%
210102	Нэмэгдэл	93,209.79	93,050.14	159.65	99.8%
210104	Урамшуулал	686.00	686.00	-	100.0%
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	11,478.68	11,458.74	19.94	99.8%
210201	Тэтгэврийн даатгал	7,964.90	7,951.33	13.57	99.8%
210202	Тэтгэмжийн даатгал	932.13	930.53	1.60	99.8%
210203	ҮОМШӨ-ний даатгал	466.13	465.33	0.81	99.8%
210204	Ажилгүйдлийн даатгал	423.16	422.36	0.81	99.8%
210205	Эрүүл мэндийн даатгал	1,692.35	1,689.20	3.15	99.8%
2104	Хангамж, бараа материалын зардал	4,812.50	4,791.80	20.70	99.6%
210401	Бичиг хэрэг	954.00	933.30	20.70	97.8%
210402	Тээвэр, шатахуун	2,798.50	2,798.50	-	100.0%
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	90.00	90.00	-	100.0%
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	970.00	970.00	-	100.0%
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	13,022.99	12,782.99	240.00	98.2%
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,460.00	1,460.00	-	100.0%
210604	Урсгал засвар	11,562.99	11,322.99	240.00	97.9%
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	28,065.70	26,215.20	1,850.50	93.4%
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	28,065.70	26,215.20	1,850.50	93.4%
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	214,169.12	214,169.12	-	100.0%
2200	Дотоод эх үүсвэрээр	214,169.12	214,169.12	-	100.0%
221001	Их засвар	134,269.12	134,269.12	-	100.0%
223001	Бусад хөрөнгө	79,900.00	79,900.00	-	100.0%
4	ТЭНЦЭЛ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ		8,118.65		
5	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		-8,118.65		
6	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт		-8,118.65		

### **3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ**

#### **Залруулсан алдаа**

Аудитаар нийт 390,500.0 мянган төгрөгийн алдаа илэрснээс аудитын явцад 390,500.0 мянган төгрөгийн алдааг залруулав.

1. Орон нутгийн төсвийн ерөнхий орлогын төлөвлөгөөг Сумын ИТХ-ын тогтоолоор баталсан дүнгээс 390,500.0 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх", Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7-д "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах" гэж заасныг болон Санхүүгийн тайлангийн "иж бүрэн байх", "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т "Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна" гэсэн заалтын дагуу залруулга хийгдсэн.

Аудитаар нийт 26,158.2 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 26,158.2 мянган төгрөгийн 2 зөвлөмж хүргүүлсэн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс материаллаг 26,158.2 мянган төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 36,480.3 мянган төгрөгөөр бага тул "**Өөрчлөлтгүй**" дүгнэлт өглөө.

#### **3.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Орлого бүрдүүлэлтэй холбоотой асуудал

##### Илрүүлэлт:

Орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө 118 хувиар давж биелсэн боловч 2 нэр төрлийн орлого 29-39 хувиар буюу 26,158.2 мянган төгрөгөөр тасарсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1-д "Батлагдсан төсвийг хэрэгжүүлэх нарийвчилсан хуваарь, төсвийн дэлгэрэнгүй хуваарилалт, төсвийн зарцуулалт болон бүрдүүлэлтэд тавих хяналтыг төсвийн сар, улирлын батлагдсан хуваарийн дагуу хэрэгжүүлнэ", 41.2.1-д "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" гэж заасныг болон санхүүгийн тайлангийн "иж бүрэн байх", "нийцсэн бөгөөд зохистой байх" зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

##### Өгсөн зөвлөмж:

Орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг нэр төрлөөр жигд биелүүлэх

**2. Хууль, тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал**

##### Илрүүлэлт:

Шилэн дансны цахим системд байршуулах 178 мэдээллээс 27 мэдээллийг хугацаа хоцроож, 150 мэдээллийг хугацаанд нь мэдээлж, 1 мэдээллийг огт мэдээлээгүй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т "Тогтоосон хугацаанд, тогтмол шуурхай мэдээлдэг байх" гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн аудитын "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Шилэн дансанд байршуулах мэдээллийг цаг хугацаанд нь иж бүрэн мэдээлэх зөвлөмж өгөв.

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасан хугацаанд ирүүлж, биелэлтийг 2026 оны 6 дугаар сарын 10-ний өдрийн дотор Төв аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 4. Санхүүгийн тайлангийн аудитад хамрагдсан байгууллагуудын санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
<b>A</b>	<b>1</b>	<b>2</b>	<b>3</b>	<b>4</b>	<b>5</b>	<b>7</b>	<b>8</b>	<b>9</b>	<b>10</b>
1	Иргэдийн төлөөлөгчдийн хурал	1		1					
2	Засаг даргын тамгын газар	1	1			1			
3	Байгалийн нөхөн сэргээлтийн барьцаа сан	1		1					
4	Хоршоо хөгжүүлэх сан	1		1					
5	Эмийн эргэлтийн сан	1		1					
6	Орон нутгийн хөгжлийн сан	1		1					
	<b>НИЙТ</b>	<b>6</b>	<b>1</b>	<b>5</b>		<b>1</b>			

#### 5. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Засаг дарга	1	390,500.0	1	390,500.0			1	390,500.0				
ЗДТГ	1	10,000.0			1	10,000.0	1	10,000.0				
ИТХ	1	1,145.0	1	1,145.0			1	1,145.0				
ХХС												
Дүн	<b>3</b>	<b>401,645.0</b>	<b>2</b>	<b>391,645.0</b>	<b>1</b>	<b>10,000.0</b>	<b>3</b>	<b>401,645.0</b>				

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

**/мянган төгрөгөөр/**

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
<b>Засаг дарга</b>	1	26,158.2					1	26,158.2				
<b>ИТХ</b>	1	1,222.0			1	1,222.0						
<b>ЗДТГ</b>	4	7,473.8	2	5,407.8			2	2,066.0				
<b>ЭЭС</b>	1	3,419.3			1	3,419.3						
<b>ХХС</b>	2	65,553.9	1	807.5	1	64,746.4						
<b>Дүн</b>	<b>9</b>	<b>103,827.2</b>	<b>3</b>	<b>6,215.3</b>	<b>3</b>	<b>69,387.7</b>	<b>3</b>	<b>28,224.2</b>	-	-	-	-

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

**/мянган төгрөгөөр/**

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
<b>Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил</b>										
<b>Засаг дарга</b>	1	-							1	-
<b>ЗДТГ</b>	-	-							-	-
<b>ХХС</b>	1	-							1	-
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>-</b>							<b>2</b>	<b>-</b>
<b>Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил</b>										
<b>Дүн</b>										
<b>Нийт дүн</b>	<b>2</b>	<b>-</b>							<b>2</b>	<b>-</b>